



## Виртуал бүсийн ажиллах журам болон тус бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд олгох татварын болон татварын бус дэмжлэг

### Хураангуй

2024 оны 6-р сарын 5-ны өдөр Монгол Улсын Их Хурал Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (МТҮДтХ)-ийг баталсан. Тус хуулийн дагуу мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг хуульчилсан ба энэхүү дэд бүтэц нь тус хуулийн хэрэгжилтийн суурь юм. Хууль батлагдсанаас хойш нэлээдгүй хугацаа өнгөрсний дараа Монгол Улсын Засгийн газар 2025 оны 9-р сарын 17-ны өдрийн 98 дугаар тогтоолоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам” (Виртуал бүсийн ажиллах журам), “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам” (Дэмжлэг үзүүлэх журам)-ыг тус тус баталсан юм. Иймд энэхүү хууль, эрх зүйн мэдээллээрээ бид та бүхэнд тус журмуудын онцлох зохицуулалтын талаар мэдээллийг хүргэж байна.

### Виртуал бүсийн тухай

МТҮДтХ-д заасны дагуу мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг цахим хэлбэрээр бүртгэснээр тус хуульд заасан дэмжлэг үзүүлэх зорилготой бүсийг “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс” (Виртуал Бүс) гэж тодорхойлсон. Виртуал Бүсийн үйл ажиллагааг Үндэсний зөвлөл (“Зөвлөл”) удирдан зохион байгуулах бөгөөд уг Зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлж, дэд даргаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд ажиллахаар зохицуулсан юм.

### Виртуал бүсийн ажиллах журам

Виртуал бүсийн ажиллах журам нь тус бүсэд хуулийн этгээдийг бүртгэх, гэрээ байгуулах, виртуал бүсээс хасахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна. Виртуал бүсийн үйл ажиллагааг цахим систем ашиглан зохион байгуулна.

### Холбоо барих:

**Серги Кобахидзе**  
Партнер  
Татвар, Хуулийн үйлчилгээ  
[sergi.kobakhidze@pwc.com](mailto:sergi.kobakhidze@pwc.com)

**Чойжамцын Цэндмаа**  
Захирал  
Татвар, Хуулийн үйлчилгээ  
[tsendmaa.choijamts@pwc.com](mailto:tsendmaa.choijamts@pwc.com)

**Өмгөөллийн  
ПрайсуотэрхаусКүүпэрс  
Легал ХХН**

Сентрал Тауэр, 6 давхар  
605 тоот, Улаанбаатар  
14200, Монгол улс  
Утас : + 976 70009089  
[www.pwc.com/mn](http://www.pwc.com/mn)

**Рагчаахүүгийн Мөнхжаргал**  
Ахлах менежер, хуульч  
Татвар, Хуулийн үйлчилгээ  
[munkhjargal.ragchaakhuu@pwc.com](mailto:munkhjargal.ragchaakhuu@pwc.com)

**Отгонтогтоолын Мөнхнасан**  
Ахлах хуульч  
Татвар, Хуулийн үйлчилгээ  
[munkhnasan.otgontogtool@pwc.com](mailto:munkhnasan.otgontogtool@pwc.com)

## Виртуал бүсийн ажиллах журам (үргэлжлэл)

Хуулийн этгээд нь төрийн үйлчилгээний нэгдсэн систем буюу И-Монголиа-р дамжуулан цахимаар бүртгүүлэх хүсэлтээ илгээнэ.

Үйл явц	Хэлбэр	
<b>Хүсэлт гаргах</b>	Цахим	<ul style="list-style-type: none"> <li>Хүсэлтийн хамт дараах мэдээллийг гаргаж өгнө. Үүнд:               <ol style="list-style-type: none"> <li>Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл;</li> <li>Хуулийн этгээдийн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт; болон</li> <li>Хуулийн этгээдийн эхлэлтийн баланс, эсхүл өмнөх жилийн санхүүгийн тайлан.</li> </ol> </li> </ul>
<b>Хүсэлт хянаж шийдвэрлэх</b>	Цахимаар мэдэгдэнэ	<ul style="list-style-type: none"> <li>Ажлын 3 өдрийн дотор хянаж, дараах шаардлагыг хангасан тохиолдолд виртуал бүсэд бүртгэх эсэх хариу мэдэгдэнэ.</li> <li>Хүсэлт шаардлага хангаагүй бол тодорхой үндэслэл, тайлбарын хамт материалыг буцаан хүргүүлнэ. Энэ тохиолдолд 5 хоногийн дотор шаардлага ханган дахин хүргүүлнэ.</li> </ul>
<b>Гэрээ байгуулах</b>	Цахим	<ul style="list-style-type: none"> <li>Зөвлөлөөс баталсан гэрээний загварын дагуу цахим хэлбэрээр гэрээ байгуулах мэдэгдлийг хуулийн этгээдэд хүргүүлнэ.</li> <li>Мэдэгдэл авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан дараах баримт бичиг, мэдээллийг Зөвлөлийн Ажлын Алба (“ЗАА”)-нд хүргүүлнэ. Үүнд:               <ol style="list-style-type: none"> <li>мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны чиглэл, бизнес төлөвлөгөө, хийгдэх ажлын дэлгэрэнгүй мэдээлэл, төсвийн тооцоо;</li> <li>байгууллагын бүтэц зохион байгуулалт, хүний нөөцийн мэдээлэл;</li> <li>зохиогчийн эрхийн гэрчилгээ, патент, ашигтай загвар эзэмшиж байгаа бол гэрчилгээний хуулбар.</li> </ol> </li> <li>Гэрээний дагуу тусгай нөхцөлийг харилцан тохиролцсоны дүнд хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн тоон гарын үсгээр баталгаажуулж, гэрээг байгуулна.</li> </ul>

Виртуал Бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээд нь санхүүгийн болон татварын тайлангаа жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор ЗАА-д хүргүүлэх үүрэгтэй.

Бүртгэлтэй хуулийн этгээдийг дараах үндэслэлээр бүртгэлээс хасна. Үүнд:

- Виртуал Бүсэд бүртгүүлсэн өдрөөс хойш 1 жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлээгүй;
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс бусад төрлийн үйл ажиллагааг виртуал бүсээр дамжуулан эрхэлсэн;
- Гэрээ, дүрэмд заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаанд үйл ажиллагаа нь өөрөөс хамаарах шалтгаанаар тасалдсан, зогссон;
- Татан буулгасан.

Дээрх үндэслэлээр бүртгэлээс хасах тухай мэдэгдлийг гэрээний хэрэгжилтийг дүгнэснээс хойш ажлын 5 өдрийн дотор тухайн хуулийн этгээдэд хүргүүлнэ. Мэдэгдлийн дагуу ажлын 5 өдөрт багтаан тайлбар өгөх эрхтэй бөгөөд энэ хугацаанд тайлбар гаргаагүй тохиолдолд хүлээн зөвшөөрсөнд тооцож, бүртгэлээс хасна.



## Дэмжлэг үзүүлэх журмын тухай

Виртуал Бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн эдлэх татварын болон татварын бус дэмжлэг тус бүртэй холбогдох мэдээллийг дор тусгав. Татварын бус дэмжлэгийн хувьд тухайн жилийн батлагдсан төсөвтэй уялдуулан санхүүжилтийн төлөвлөгөөг жил бүрийн 2 дугаар сард багтаан Зөвлөл батлахаар заасан.




### Татварын дэмжлэг

- Татварын дэмжлэг үзүүлэхэд тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан татварын хууль тогтоомжийг баримтална.
- Татварын дэмжлэг авах хүсэлтээ харьяалах татварын байгууллагад гаргана.
- ЗАА татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэхтэй холбоотой зөвлөгөө, туслалцааг хуулийн этгээдэд үзүүлнэ.
- Татварын ерөнхий хуулийн 10.2-н дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааны журмын дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдэлнэ.



### Татварын бус дэмжлэг



Татварын бус дэмжлэгүүд болон журмын зохицуулалтыг дор тусгав.

### Татварын бус дэмжлэгийн төрлүүд

- мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагад патентжуулах зардлыг санхүүжүүлэхэд грант олгох
- экспортод чиглэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүний олон улсын чанар, стандартын баталгаажуулалтын зардлыг санхүүжүүлэхэд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн грант олгох
- виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд нөхөн олговор олгох
- хиймэл оюун ухаанд суурилсан төсөл, арга хэмжээний нийт өртгийн 60 болон түүнээс дээш хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдэх хэсэгт грант олгох
- дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгосон патент эзэмшигчид шагнал, урамшуулал олгох
- Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасан нөхцөл журмын дагуу зээлийн батлан даалт гаргах
- экспортод гаргасан болон оюуны өмчид бүртгүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрд судалгаа, хөгжүүлэлтийн зардлын 70 хүртэлх хувьтай тэнцэх нэг удаагийн дэмжлэгийг дотоодын мэдээлэл технологийн гарааны компанид олгох
- мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төсөл хэрэгжүүлэхээр авсан зээлийн хүүгийн тодорхой хувийг санхүүжүүлэх
- мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж гарааны компанид эд хөрөнгийн түргэвчилсэн элэгдэл хорогдол тооцох

### Журмын зохицуулалт

- Хуульд заасан эх үүсвэрийн мөнгөн дүнтэй уялдуулна
- Хуульд заасан эх үүсвэрийн мөнгөн дүнтэй уялдуулна
- Тухайн жилд нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн үнийн дүнтэй тэнцэхүйц хэмжээгээр олгоно
- Хуульд заасан эх үүсвэрийн мөнгөн дүнтэй уялдуулна
- Мөнгөн хэлбэрээр олгоно
- Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль тогтоомжид заасны дагуу олгоно.
- Хуульд заасан эх үүсвэрийн мөнгөн дүнтэй уялдуулж гарааны компанид олгоно
- Виртуал Бүсэд бүртгэгдсэнээс хойш авсан зээлийн хүрээнд шийдвэрлэнэ
- Гарааны компанид олгоно.

## Бидэнтэй холбогдоорой

Батлагдсан журмуудтай [ЭНД](#) дарж танилцана уу. Та бүхэнд энэхүү мэдээлэлтэй холбоотой аливаа асуух зүйл байвал бидэнтэй холбогдоорой.

[www.pwc.com/mn](http://www.pwc.com/mn)

© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ. Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээлэлд үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.